

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ ТӨМӨРХҮҮГ ОВОГТОЙ АРИУНААГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биел эл-тийн хувь			
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)							
			1	2	3	4	5	6	7			
Зорилт 1: "Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дүнд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:												
1.1.	Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах;	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕТ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	738	Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зөвлөмжийг хүргүүлсэнт хэрэгжүүлэн ажиллаж байна.					Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас ирүүлсэн зарим асуулгад холбогдох хууль, журам, дүрэм, зааврыг үндэслэн зөвлөмж хүргүүлсэнт танилцаж, тэтгэвэр тэтгэмж тогтоолтонд хэрэгжүүлэн ажиллаж байна	2025.01.01 2025.06.30	100 хувь

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүрчийг хэрэгжүүлэх зорилт

Зорилт 2: "Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэрэгжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

2.1	Тэтгэврийн байцаагчийн шинээр тогтоосон тэтгэврийн үндэслэлийг шалгаж, тогтоолт, бодолтгод хяналт тавих;	Тогтоосон тэтгэврийн үндэслэлийг шалгаж зөрчлийг арилгуулсан байх;	100 хувь	100 хувь	Хагас жилийн байдлаар нийт 373 тэтгэвэр шинээр тогтоосон байна. Шинээр тогтоосон тэтгэврийн үндэслэлэлийг: 1. Баримт бичгийн бүрдэл 2. Тогтоолт, тэтгэвэр бодолт нь хууль, журмын дагуу бодогдсон эсэхийг хянан, тасгийн даргаар баталгаажуулан ажиглаж байна. Тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан иргэний бүрдүүлсэн материал, тэтгэвэр тогтоолтыг шалгахад дахин материал бүрдүүлэх шаардлагатай 18 даатгуулагчийн хүсэлтийг буцааж, дахин бүрдүүлэлт хийлгэсэн. Тэтгэвэр тогтоолтын баримт бичгийн бүрдэлд хүүхдийн гэрчилгээний лавлагаа болон 1990-1994 оны малчин байсан хугацааны сүм, баг, хорооны засаг даргын тодорхойлолтод хяналт шалгалт хийх нөхцөл боломж тулгамдаж байна. Энэ онд багийн засаг дарга нар шинээр томилогдсонтой холбоотойгоор малчин тодорхойлолтын үндэслэлийг хянан, баталгаажуулан ажиглахыг сумын байцаагч нарт мэдэгдэж ажиглалаа. Мөн хүүхдийн гэрчилгээний лавлагаа дээр үрчилсэн, үрчилж авсан, нас барсан шалгааныг хянах боломжгүй тул өргөдлийн маягтад тусгагдсан хүүхдийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн байх шаардлага тавин ажиглаж байна. Тэтгэвэр тогтоолтын үндэслэлд дараах зөрчил илэрсэн байна:	100 хувь
-----	--	--	----------	----------	--	----------

				• Энгийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоосон зөрчил - 1 • Эрх үүсээгүй өндөр насны тэтгэвэр /хүүхдийн нөхцөл/ -1 • Эрх үүсээгүй өндөр насны малчин тэтгэвэр -1 • Даатгуулагчийн төрлийг /22011/ буруу тайлагнасан улмаас тэтгэврийн эрх үүсээгүй -1 Мөн шинээр хүсэлт гаргасан 2 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэврийг хувь тэнцсэн тэтгэвэр тогтоосон байсныг залруулсан байна. Энэ хагас жилд нийт 220 өндөр насны тэтгэвэр тогтоолгосноос 15 хэвийн бус нөхцөлөөр тогтоосон байна. Манай аймгийн ДБЭХС-д ажиллаж байгаа ажилчдын албан тушаал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан ажил мэргэжлийн жагсаалтад байгаа албан тушаалын нэртэй зөрүүтэй бичигдсэн хортой нөхцөлийн тэтгэврийг албан тушаалын тодорхойлолтой тулган 3 хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Тэтгэврийн хувийн хэргийн эмц цэгцийг хангуулах үүднээс шаардлагагүй, шаардлагатай дутуу баримт ирүүлсэн байцаагч тус бүрт мэдэгддэг боловч үр дүн харагдахгүй байна. Иймд хамгийн эмх цэгцтэй байцаагч буюу /1 үдээстэй хувийн	2025.01.01	
					2025.06.30	

					хэрэг/ шалгаруулан урамшуулах идэвхшүүлэх, саналтай байна.		
2.2	Тэтгэврийн хувь, хэмжээг өөрчлүүлж буй тэтгэвэр авагчдын анхан шатны баримтын үндэслэл болон өөрчлөн бодолтыг хянах;	Баримтын үндэслэлийг Хянаж зөрчлийг арилгуулсан байна			Цэргийн алба хаасан тэтгэвэр авагч энгийн жилээ нэмэгдүүлэх 28 тэтгэвэр авагч хүсэлт ирүүлснээс 27 тэтгэвэр авагчийн тэтгэврийн нэмэгдлийг хянаж, шийдвэрлэсэн байна. Хүсэлт гаргасан 1 тэтгэвэр авагч нь 2010 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон учир 2010 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуулиас өмнө хуулийн зохицуулалт байхгүй тул өргөдлийг буцаасан байна.	2025.01.01 2025.06.30	100 хувь
2.3	Хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын хугацааны сунгалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах;	Тэтгэвэр авагчдын хугацааны сунгалтад хяналт тавьж, зөрчлийг арилгуулсан байх.		1080	Аймгийн хэмжээнд нийт хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг 2680 даатгуулагч, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 752 даатгуулагчдад тэтгэврийн даатгалын сангаас тус тус олгож байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаагаа сунгасан даатгуулагчийн мэдээллийг "Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадласан шийдвэрийн хуудас"-тай тулган шалгасан байна. Систем шинэчлэгдсэнтэй холбоотойгоор "Эрүүл мэндийн магадлалын зөвлөл"-ийн системээс татагдаж, хянагдаж байна. "Эрүүл мэндийн магадлалын зөвлөл"-ийн системд алдаатай шивэгдсэн 2 даатгуулагчийн мэдээлэл зөрсөнг магадлагч эмчээр хянуулж зөрчлийг арилгаж ажилласан байна. Системд шийдвэрлэгдэхгүй байгаа тэтгэвэр авагчийн мэдээллийн сангийн бүртгэлийг системд хэрхэн шийдвэрлэхэд суралцахын зэрэгцээ зөвлөгөө өгч ажиллаж байна.	2025.01.01 2025.06.30	100 хувь
2.4	Тэтгэмжийн байцаагчийн шинээр тогтоосон тэтгэмжийн баримтын бүрдлийг шалгаж, хяналт тавих.	Тогтоосон тэтгэмжийн хувийн хэрэгт хяналт тавьж	100 хувь	100 хувь	Хагас жилийн байдлаар; Ажилгүйдлийн тэтгэмж - 310		100 хувь

		зөрчлийг арилгуулсан байх.			• Жирэмсний болон амаржсаны тэтгэмж - 512 • Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж - 180 • Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж - 1267 • ҮОМШӨ Сувицалд ирж очих унааны зардал - 3 • ҮОМШӨ Сэргээн засах сувиллын зардал - 1 • ҮОМШӨ Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж- 34 тус тус хянаж баталгаажуулж шийдвэрлэсэн байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн хяналт хийх явцад тэтгэмж бодох цалин хөлсийг давхардуулан бодсон 6, тэтгэмжийн эрх үүсээгүй 2 хүсэлтийг буцаасан. Системд ажил олгогч нь даатгуулагчийн төрөл буруу тайлагнасан учир алдаа зөрчил давтагдаж байна. Мөн баримт бичгийн зөрчилтэй тушаал үндэслэлгүй 2 даатгуулагчийн тэтгэмжийг буцааж, зөрчлийг арилгасан байна.	2025.01.01 2025.06.30	
2.5	Тэтгэврийн өөрчлөн тогтоолт, баримтын бүрдлийг шалгах, хяналт тавих	Тэтгэвэр олголтын үйлчилгээг хугацаанд чанартай үзүүлэх,			2024 оноос Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч өөрөө хувьэл тэтгэврийн даатгалд даатгуулахгүй байх хууль хэрэгжиж эхэлсэн. Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлснөөр тэтгэврийн нэмэгдэл хийлгэх 112 хүсэлт ирснээс тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насанд хүрээгүй 25 даатгуулагч 22011 төрлөөр тайлагнасан зөрчил гарсан байна. Уг зөрчлийг арилгуулахаар орлого, шимтгэлийн байцаагчдад тайлан авахад анхаарахыг сануулан ажиллаж байна.	2025.01.01 2025.06.30	

Тэтгэвэр авагчдын хувийн хэрэг, хавсаргасан баримтыг тэтгэвэр авагчдын жагсаалттай тулган жилд 2 удаа тооллого явуулах, тэтгэврийн хувийн хэрэг дутсан тохиолдолд шалтгааныг тодруулан нөхөн бүрдүүлэх;	Тооллого шалгалтыг хийж, холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.		Систем шинэчлэгдсэнээр тэтгэвэр авагчийн массивын дугаар одоо байгаа хувийн хэргийн дугаартай таарахгүй байгаа нь тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийхэд хүндрэлтэй байна. Иймд хагас жилийн хугацаанд тооллого хийх боломжгүй байсан болно.	2025.01.01 2025.06.30 100 хувь
Дөрөө. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт. Зорилт 4.1: “Төрийн захиргааны удирдлагын манлайлыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөөлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөөлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
4.1.1 Иргэд, даатгуулагчаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;	Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2024 онд 98%-тай хэрэгжсэн байна.	Энэ онд 2 иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолтыг дахин хянуулах өргөдөл гаргасан байна. Тус 2 тэтгэвэр тогтоолтыг хянахад хуулийн дагуу тогтоогдсон байсанг мэдэгдэж, зөвлөгөө өгч ажиллагаа.	
Зорилт 4.3: “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэсийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
4.3.1 Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, мэдээ мэдээлэл өгөх, сард 1-оос доошгүй удаа;	Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 1-оос доошгүй удаа;	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан.	Нийгмийн даатгалын байгууллага нь үйл ажиллагаагаа сайжруулах, иргэдэд тасралтгүй мэдээлэл өгөх зорилгоор цахим мэдээллийн хэрэгслээр тогтмол сургалт суртчилгааны мэдээлэл, видео мэдээлэл, шторк зэргийг хүргүүлж байна. Тус цахим сурталчлагааг өөрийн цахим хаягаар сурталчлан ажиллаж байна.	

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ				
1.	Багаар ажиллах, асуудал шийдвэрлэх, бусдад мэдээлэл хүргэх ур чадварт суралцах;	Гүйцэтгэж байгаа албан үүргээ чанартай гүйцэтгэх;	Нийгмийн даатгалын мэдээллийн "Sicos" системийн талаар нэгдсэн ойлголттой болгох, дадлага хийх, системийн дата мэдээллийг ашиглах, процессын шинжтэй ажлуудыг хөнгөвчлөх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтад /2025.04.28,29/ хоёр өдөр хамрагдлаа.	
2.	Хууль тогтоомжийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх, зохион байгуулсан сургалтад хамрагдах;	Мэдлэг, чадвар дээшилсэн байна	Төрийн албаны зөвлөлөөс Хэнтий аймгийн Чингис хотод зохион байгуулсан "Төрийн албаны манлайлал" зүүн бүсийн зөвлөгөөнд оролцов. Тус зөвлөгөөнөөр "Төрийн хаагчийн ёс зүйн асуудал, хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдвийн хэлэлцүүлэгт тус хууль хэрэгжүүлснээр гарах ур дүнгийн талаар санал бодлоо солилцлоо.	

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТЭГТЭВЭР, ТЭГТЭМЖИЙН ХЯНАЛТЫН
БАЙЦААГЧ
(Албан тушаал)

..... /Т.АРИУНАА /

(Нэр, гарын үсэг)

2025.06.20
(Огноо)